



Монгол Улсын  
Үндэсний статистикийн  
хороо

# **“Ардчилсан засаглал судалгаа”-ны 2016-2018 оны үр дүн**

УЛААНБААТАР 2019

# Агуулга

---

БҮЛЭГ I. УДИРТГАЛ	3
1.1 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл	3
1.2 Судалгааны зорилго, ач холбогдол	3
1.3 Судалгааны арга зүй	3
БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	4
2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ	4
2.2 Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ	6
2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн үнэлгээ	10

## БҮЛЭГ I. УДИРТГАЛ

### 1.1 Ардчилсан засаглал судалгааг явуулах шаардлага, үндэслэл

Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13-р тогтоолд Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгохыг Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисст тухайн үед үүрэг болгосон.

Мянганы хөгжлийн зорилтын 9-р зорилгын 3 шалгуур үзүүлэлт нь олон нийтийн үнэлгээний үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлтүүдийг олон улсын туршлага, санаачилгыг харгалзан Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос тогтмол зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа-(ӨНЭЗС)”-ны хавсралт /модуль/ судалгаагаар цуглуулахаар ҮСХ-ны даргын 2008 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 10/100 тоот тушаалаар судалгааны үзэл баримтлалыг баталсан. Харин 2018 онд "Ардчилсан засаглал судалгаа"-ны асуулгыг "Тогтвортой хөгжлийн зорилт"-ын шалгуур үзүүлэлтүүдээр баяжуулан шинэчилж, ҮСХ-ны даргын 2018 оны 9-р сарын 19-ний өдрийн А/98 тоот тушаалаар батлуулан мэдээлэл цуглуулалтад ашиглаж байна.

### 1.2 Судалгааны зорилго

Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүд, Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн “Чанартай боловсролыг дэмжих” 4-р зорилго, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” 5-р зорилго, “Энх тайван, шударга ёсыг цогцлоох” 16-р зорилго, “Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх” 17-р зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлоход чиглэгдсэн.

### 1.3 Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны судлагдах нэгж нь ҮСХ-ноос сар бүр тогтмол явуулж байгаа Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд хамрагдсан өрхийн 15, түүнээс дээш насны нэг гишүүн байна.

Судалгааны түүвэрлэлт нь ӨНЭЗС-ны дэд түүвэрлэлт бөгөөд түүврийн хэмжээ нь 2748 хүн юм. Түүвэрлэлтийг хийхдээ эхний шатанд ӨНЭЗС-нд сонгогдсон өрхүүдээс 2748 өрхийг түүвэрлэн сонгосон.

Хоёр дахь шатанд тухайн өрхөд амьдарч буй 15, түүнээс дээш насны өрхийн гишүүдийн жагсаалтаас санамсаргүй тооны Кишийн хүснэгтийн аргыг ашиглан судалгаанд хамрагдах хүнийг сонгосон.

## БҮЛЭГ II. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

“Ардчилсан засаглал” судалгааг 2008 оны III улирлаас эхлэн явуулж буй бөгөөд энэ удаад “Ардчилсан засаглал” судалгааны 2016 - 2018 оны үр дүнг харьцуулан танилцуулж байна.

### 2.1 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, санхүү, эдийн засгийн хувьд хараат бус байдал хангагдсан эсэхээр илэрхийлэгдэнэ. Энэхүү хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.1-т харууллаа. Оноо нь бага байх тутам хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг гэдэгтэй иргэд санал нийлэхгүй байгааг, харин оноо нь ихсэх буюу 100-д ойртох тутам санал нийлж байгааг харуулна.


**Зураг 2.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээ, оноогоор, 2016-2018 он**



Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээг харахад 2016 онд энэ үзүүлэлт 18.1 байсан бол 2018 онд 22.6 болж өссөн байна. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн эдийн засаг, санхүүгээс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээ 2016 онд 19.6 байсан бол 2018 онд 19.1 болж буурсан байна.


Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдалд өгсөн иргэдийн үнэлгээг авч үзэхэд 2017 онд нийт иргэдийн 35 хувь, 2018 онд 34 хувь нь хараат бус гэдэгтэй санал нийлдэггүй гэж хариулсан байна. Харин дунд зэрэг гэж хариулсан иргэд 2017 онд 27 хувь байсан бол 2018 онд 22 хувь болж буурсан. Санал нийлдэг гэж хариулсан иргэд 2017 онд 9 хувь байсан бол 2018 онд 10 хувь болж өссөн байна. 2017 онд нийт иргэдийн 29 хувь нь, 2018 онд 34 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ /Зураг 2.2/.

**Зураг 2.2. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2016-2018 он**



Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.3-т харууллаа. Иргэдийн өгсөн үнэлгээг 2016-2018 оноор авч үзэхэд Монголын үндэсний олон нийтийн телевизэд өгсөн үнэлгээ 87.5-аас 69.5 оноо, Үндэсний радиод өгсөн иргэдийн үнэлгээ 78.1-ээс 50.0 оноо, хувийн телевизэд өгсөн үнэлгээ 75.6-аас 66.4 оноо, FM радиод өгсөн үнэлгээ 58.7-оос 54.6 оноо болж тус тус буурсан байна. Харин орон нутгийн телевизэд өгсөн иргэдийн үнэлгээ 76.8-аас 87.1, өдөр тутмын хэвлэлд өгсөн иргэдийн үнэлгээ 63.3-аас 73.5 болж тус тус өссөн байна /Зураг 2.3/.

**Зураг 2.3. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, оноогоор, 2016-2018 он**



## 2.2 Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ

Төрийн захиргааны дээд байгууллагууд, түүний дотор хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн өгсөн хариулт нь хүн амын дунд засаг, төрийн байгууллагуудад хэр зэрэг итгэл хүлээлгэж буйг илэрхийлэх үзүүлэлт юм.


Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн төсөөллийг 0-100 оноонд шилжүүлэн Зураг 2.4-т харууллаа.

Төрийн эрх барих дээд байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг авч үзэхэд Ерөнхийлөгчид өгсөн үнэлгээ 2016 онд 34, 2017 онд 49, 2018 онд 44, Улсын их хуралд өгсөн үнэлгээ 2016 онд 21, 2017 онд 33, 2018 онд 13, Засгийн газарт өгсөн үнэлгээ 2016 онд 25, 2017 онд 37, 2018 онд 22 байна.

Төрийн захиргааны бусад байгууллагуудад өгсөн иргэдийн үнэлгээг 2016-2018 оноор авч үзэхэд Замын цагдаагийн албанд өгсөн үнэлгээ 80-аас 84, Эрүүгийн цагдаагийн албанд өгсөн иргэдийн үнэлгээ 79-өөс 83, нийгмийн халамжийн байгууллагад өгсөн үнэлгээ 83-аас 85, даатгалын байгууллагад өгсөн иргэдийн үнэлгээ 84-өөс 87 болж өссөн байна.




**Зураг 2.4. Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн үнэлгээ, оноогоор, 2016-2018 он**



Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-т итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг дүнд эзлэх хувиар нь гаргаж харууллаа.


Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2016-2018 оноор авч үзэхэд ерөнхийлөгчид итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 39.9 хувь, 2017 онд 29.0 хувь, 2018 онд 35.3 хувь, дунд зэрэг гэж хариулсан иргэдийнх 2016 онд 39.1 хувь, 2017 онд 39.7 хувь, 2018 онд 38.8 хувь, итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2016 онд 14.8 хувь, 2017 онд 22.7 хувь, 2018 онд 18.1 хувьтай байна. Харин мэдэхгүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 6.3, 2017 онд 8.7, 2018 онд 7.8 хувь байна.

**Зураг 2.5. Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2016-2018 он**




УИХ-д итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2016-2018 оноор авч үзэхэд, итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 33.2, 2017 онд 35.1, 2018 онд 58.5, дунд зэрэг итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2016 онд 37.2, 2017 онд 41.7, 2018 онд 28.1, итгэдэг гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 12.9, 2017 онд 15.2, 2018 онд 6.5 хувь байна.

**Зураг 2.6. УИХ-д итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2016-2018 он**



Засгийн газарт итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2016-2018 оноор авч үзэхэд итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 42.6, 2017 онд 32.8, 2018 онд 50.0, дунд зэрэг гэж хариулсан иргэдийнх 2016 онд 37.8, 2017 онд 42.0, 2018 онд 33.2, итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2016 онд 13.0, 2017 онд 16.2, 2018 онд 9.5 хувь байсан бол мэдэхгүй гэж хариулсан иргэдийнх 2016 онд 6.7, 2017 онд 9.0, 2018 онд 7.3 хувь байна.

**Зураг 2.7. Засгийн газарт итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээ, дүнд эзлэх хувиар, 2016-2018 он**



### **2.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн үнэлгээ**

Судалгаанд оролцсон иргэдээс сүүлийн 12 сард төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авсан эсэхийг асууж, “Тийм” гэж хариулсан бол тухайн иргэдээс үйлчилгээ авах үед авлига ажиглагдсан эсэхийг тодруулж асуусан /Зураг 2.8/. Уг асуултыг асуухдаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээ авах тохиолдол бүрээр нэр зааж асуусан бөгөөд авлига ажиглагдсан гэж арай түлхүү хариулсан үйлчилгээний төрлөөр үр дүнг харууллаа.

**Зураг 2.8. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээнд авлига ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь, 2016-2018 он**



Сүүлийн 12 сард эмнэлгийн үйлчилгээ авахад авилга ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 5.2 хувь, 2017 онд 4.6 хувь, 2018 онд 3.1 хувь байна. Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлыг шийдэх үед авилга ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 2.1 хувь, 2017 онд 2.4 хувь, 2018 онд 1.3 хувь, хүүхэд сургууль, цэцэрлэгт оруулах үед авилга ажиглагдсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2016 онд 1.4 хувь, 2017 онд 1.6 хувь, 2018 онд 2.7 хувь байна.